

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН  
ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН  
(2021, 2022, 2023 оны шалгуур үзүүлэлтээр)

2024 оны 01 дүгээр сарын 19

Улаанбаатар хот

**Бүлэг:** Дөрөв. Эдийн засаг

**Зорилго:** 4. Инновацад тулгуурласан, өрсөлдөх чадвартай үйлдвэрлэл, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, оюуны бөөгнөрлийг дэмжиж, бүтээлч, бие даасан, тогтвортой эдийн засагтай хот болгох суурийг бүрдүүлнэ.

**Зорилт:** 4.3. Эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, бүтээлч эдийн засгийг хөгжүүлнэ.

**Дэд зорилт:** 4.3.1. Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлсэн байна.



**Шалгуур үзүүлэлт 1:** Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ

**Суурь түвшин:** -

**Зорилтот түвшин:** 1

**Хэрэгжилт:** Нийслэлийн аялал жуулчлалыг 2022-2025 онд хөгжүүлэх 4 жилийн арга хэмжээний төслийг 2021 онд Үндэсний хөгжлийн газар, салбарын мэргэжлийн холбоодтой хамтран 30 гаруй байгууллагаас санал авч боловсруулсан. Төслийг Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Улаанбаатар хотын аялал жуулчлалыг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/599 дүгээр захирамжаар нийслэлийн Аялал жуулчлалыг хөгжүүлэх “Найрсаг Улаанбаатар-2” арга хэмжээг батлуулсан.

“Найрсаг Улаанбаатар-2” арга хэмжээг хэрэгжүүлэх 7 зорилтын 77 арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 2022 онд 70%, 2023 онд 80%-ийн хэрэгжилттэй байна.



## Шалгуур үзүүлэлт 2: Хүлээн авах гадаад жуулчдын тоо

**Суурь түвшин:** 500,000

**Зорилтот түвшин:** 750,000

**Хэрэгжилт:** Монгол Улс 2021 онд 33,100, 2022 онд 286,282 гадаадын жуулчин хүлээн авсан. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогтоолоор 2023-2024 оныг “Монголд зочлох жил” болгон зарлаж 2023 онд 1 сая жуулчин хүлээн авах зорилт дэвшүүлсэн. “Монголд зочлох жил”-ийн хүрээнд 2023 онд нийт 651,061 гадаадын жуулчин хүлээн авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 364,779 жуулчнаар буюу 43.9 хувийн өсөлттэй байна.

Зорин ирж буй жуулчдыг улсаар нь авч үзвэл нийт жуулчдын 35.19%-ийг ОХУ, 21.91%-ийг БНСУ, 20.86%-ийг БНХАУ, 3.29%-ийг БНКазахстан Улс, 3.13%-ийг Япон улсын жуулчид эзэлж Монгол Улсын зорин ирсэн үзүүлэлттэй байна.

## Шалгуур үзүүлэлт 3: Шинээр нэвтрүүлсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ

**Суурь түвшин:** 13

**Зорилтот түвшин:** 18

**Хэрэгжилт:** Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор 2021 онд Сонгинохайрхан уулын явган аяллын замын тохижилт (63,183,533 төгрөг), “Хийморь” олон улсын морьт харвааны наадам, (10,167,000 төгрөг) “Уухай” шагайн харвааны наадам (11,488,000 төгрөг) зэрэг 3 арга хэмжээ, 2022 онд “Их тэнгэрийн амны хадны зураг” орчны тохижилт (135,909,501), “Нэг жуулчин-нэг мод” жуулчин төгөл зэрэг 2 арга хэмжээг шинээр хийж гүйцэтгэсэн.

2023 онд “Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолборын тохижилт (518,700,000 төгрөг), “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль, “UB bike tour” олон улсын дугуйн фестиваль, “POWER EXPO & FESTIVAL” экстрим, экспо, энтертайнмент арга хэмжээ (49,251,929 төгрөг) зэрэг 4 арга хэмжээ нийт 9 аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр нэвтрүүллээ.


❖ 2023 оны зурагнууд

Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолборын тохижилт





“Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль






UB bike tour” олон улсын дугуйн фестиваль





"POWER EXPO & FESTIVAL" экстрим, экспо, энтэртайнмент арга хэмжээ



ТАНИЛЦСАН:  
ДАРГА



Д.БАТСҮХ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Д.ГАНБОЛД

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТОГТООЛ  
ШИЙДВЭРИЙН БИВЭЛЭЛТ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН

О.НЯМБАТ